

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
САЙНЦАГААН СУМАНД ХАМААРАЛТАЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

2021.11сар

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилт от түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь
					Он	Түвшин			
1. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО									
2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
2.3 . Боловсрол									
2.3.1.1	<u>Арга хэмжээ:</u> Сайнцагаан суманд шинээр цэцэрлэгийн барилга барих	2021-2024	1000.0	Ашиглалтад шинээр орсон цэцэрлэгийн тоо	2020	2	3	9-р цэцэрлэгийн зураг төсөв хийгдэж байгаа. Тус цэцэрлэгийг барих болсон үндэслэлийг ХОХБХэлтэст хүргүүллээ. 2-р цэцэрлэгийн шинэ барилгын зураг төсөв аймгийн МХГазраар хянагдан дүгнэлт гарч магадлалаар орох шатандаа явж байна. 2022 оны төсөвт жагсаалтаар орсон.	30
2.3.2.1	<u>Арга хэмжээ:</u> Сайнцагаан суманд шинээр сургуулийн барилга барих	2021-2024	2000.0	Ашиглалтад шинээр орсон сургуулийн тоо	2020	0	1	Улсын төсвийн 10.5 тэр бумын хөрөнгө оруулалтаар ГИЦС-ийн барилгыг ашиглалтанд оруулах бөгөөд энэ онд 2.7 тэр бумын хөрөнгөөр барилгын суурийн цутгалтыг СНВJ ХХК хийж гүйцэтгэлээ.	30
2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал									
2.4.2.3	<u>Арга хэмжээ:</u> Хөдөлмөр эрхлэх төсөлд 180 иргэнийг нэмж хамруулан, байнгын ажлын байртай болгох	2021-2024	-	Төслийн үр дүнд бий болсон ажлын байрны тоо	2019	173	193	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт-5 иргэн, Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийг сэргээх хөтөлбөрт-12 иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн дэмжих хөтөлбөрт-4 иргэн, Малжуулах арга	100

								хэмжээнд- 2 иргэнд зээл олгосноор 4 төсөл хөтөлбөрөөр 16 ажлын байр шинээр бий боллоо.	
2.4.2.1	<u>Дэд зорилт:</u> Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай эрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэний байнгын ажлын байр 2020 онд 14 хувь байсныг 2024 онд 34 хувьд хүргэнэ.	2021-2024	292.3	Байнгын ажлын байрыг нэмэгдүүлсэн хувь	2020	14	18	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 233 өрхөөс хөдөлмөр эрхлэх чадвартай 221 иргэнээс 20 иргэнийг байнгын ажилд зуучиллаа.	70
2.4.2.1.1	<u>Арга хэмжээ:</u> 310 ба түүнээс доош оноотой эрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулах	2021-2024	240.0	Үйлчилгээнд хамрагдсан иргэний хувь	2020	348	6	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ хамрагддаг өрхүүдийн хөдөлмөр эрхэлдэггүй 15 иргэнийг хамрууллаа.	70
2.4.2.1.2	<u>Арга хэмжээ:</u> 310 ба түүнээс доош оноотой эрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийн жил бүр 20 хувийг нь мэргэжил	2021-2024	2.3	Сургалтад хамрагдсан иргэний хувь	2020	0	20	310 ба түүнээс доош оноотой буюу Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 187 өрхийн хөдөлмөр эрхэлддэггүй иргэдээс 30 иргэнийг мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрууллаа.	70

	эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулах								
2.4.2.1.3	<u>Арга хэмжээ:</u> Жил бүр мэргэжил эзэмшүүлэх сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 10 хувийг хөтөлбөр төсөлд хамруулах	2021-2024	50.0	Хөтөлбөр, төсөлд хамрагдсан иргэний хувь	2020	0	10	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ хамрагддаг өрхүүдийн хөдөлмөр эрхэлдэггүй 15 иргэнийг хамруулж 2022 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулахаар төлөвлөлөө.	70
2.4.2.1.4	<u>Арга хэмжээ:</u> 310 ба түүнээс доош оноотой өрхийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах	2021-2024		Тухайн жилд ажлын байранд зуучилсан иргэний тоо	2020	209	52	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ хамрагддаг өрхийн хөдөлмөр эрхэлдэггүй 92 иргэнийг түр ажлын байранд, 15 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.	100
2.4.3.1	<u>Арга хэмжээ:</u> Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд тогтмол хамруулах	2021-2024	-	Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ оношилгоонд хамрагдсан ахмад настны эзлэх хувь	2019	37.2	43	Сумын засаг даргын удирдамжаар сум, Өрхийн ЭМТөвүүдтэй хамтран 2 сарын аян зохион байгуулан ахмад настныг урьдчилан сэргийлэх 780 ахмад настанг хамрууллаа.	100
2.4.3.2	<u>Арга хэмжээ:</u> Ахмад настнуудыг нас,	2021-2024	-	Алхалт, дасгал хөдөлгөөнд	2019	1200	1285	Улс, аймгийн Цахим гүйлт, Дасгал хөдөлгөөн хийцгээе аянд сумын 50 гаруй ахмад настан оролцлоо. Цар	100

	бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах			хамрагдсан ахмад настны тоо				тахлаас шалтгаалан ахмадын дундах арга хэмжээ зохион байгуулагдаагүй. Тогтмол дасгал хөдөлгөөн, алхалт хийдэг 130 гаруй ахмад настан байна.	
2.4.3.3	<u>Арга хэмжээ:</u> Аймгийн ахмадын спорт, урлагийн бага наадмыг зохион байгуулах	2021-2024	5.0	Бага наадамд оролцсон ахмад настны тоо	2020	135	125	Аймгийн урлагийн бага наадамд 6 төрөлд 1,2,3-р байр эзэлж, багаараа тусгай байранд шалгарсан амжилт үзүүлж, сумын засаг дарга ахмад настнуудад хүндэтгэл үзүүллээ.	100
2.4.4	<u>Зорилт:</u> Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилт 2019 онд 85 хувь байсныг 2024 онд 90 хувьд хүргэнэ.	2021-2024	155.6	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2020	85	86	Сумын Хамтарсан баг гишүүдийн хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээг сумын ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран 2 сарын аянг зохион байгууллаа. Баг бүр Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Хүүхдийн эрх хамгааллын тухай хууль, Хамтарсан багийн үйл ажиллагааны талаар 2-3 төрлийн гарын авлага боловсруулан 750 иргэдэд тарааж, цахимаар хүргэсэн мэдээ мэдээллийг 8200 гаруй иргэн хандалт хийсэн байна. Цагдаагийн газрын хүүхдийн байцаагчтай хамтран 21 хүүхдэд гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгууллаа. “Дэлгэцийн донтолт” сэдвээр насанд хүрээгүй хүүхдүүдэд 7 слайд бүхий сургалтыг цахимаар хүргэж 172 иргэн үзэж судаллаа. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “Хүчирхийлэлгүй	100

							<p>үлгэр жишээ гэр бүл"-ээр 5 өрхийг шалгаруулан "Түмэн хишиг хурайлах" ХХК 400000 төгрөгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа.</p> <p>Хүүхдийн аюулгүй байдлын талаар Тэжээвэр нохойтой өрхүүдэд Зөрчлийн тухай хуулиас санамж бэлтгэн тараалаа. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлэх, таслан зогсоох, хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд хүн бүрийн оролцоо чухал болохыг иргэдэд уриалах зорилгоор "Хүүхдэд ээлтэй хөрш" 14 хоногийн аяныг 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлээд байна. Уг аяны хүрээнд "ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХӨРШ БАЙЯ" уриалга болгож зурагт ханыг бүтээлээ.</p> <p>Сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 4 сүм, хийдийн хүүхдийн эрх, хамгааллын бодлогын хэрэгжилттэй танилцаж, зөвлөгөө зөвлөмж хүүхдийн талаар төрөөс баримталж буй бодлогуудаар хуулийн багц боловсруулан, ёс зүйн гэрээ байгуулж, батламж гардууллаа.</p> <p>Хамтарсан баг аяны хүрээнд Хамтарсан баг, ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг сурталчилах мэдээллийн самбарыг олон нийтийн газар байрлуулахад 180000, сургууль бүрт хүүхдийн элч ажиллуулан, School police- нарыг хантаазаар хангаж 350000 төгрөг ,</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

								хөдөөгийн 4 багийн 200 өрхийг хуулийн богцоор хангах, архины хамааралтай эмэгтэйчүүдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, цахимаар урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг байрлуулах ажлыг зохион байгуулж байна.	
2.4.4.1	<u>Арга хэмжээ:</u> Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 65-аас доошгүй хувийг чадваржуулах сургалтад хамруулах	2021-2024		Сургалтад хамрагдсан үүрэг хүлээгчдийн хувь	2020	25	35	Байгууллага бүрийн гэр бүлийн зөвлөл албан хаагчдын дунд цахим болон танхимаар 10 төрлийн сургалт , арга хэмжээг зохион байгуулж 600 гаруй албан хаагч хамрагдлаа. Сумын Хамтарсан баг гишүүдийн хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх арга хэмжээг сумын ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран 2 сарын аянг зохион байгуулан гишүүдийг чадваржуулах сургалт, Аймгийн ГБХЗХГ-аас Хамтарсан багийн гишүүдийг аргазүйгээр хангах цахим сургалтанд хамрууллаа.	100
2.4.5	<u>Зорилт:</u> Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын дундаж хувь 2019 онд 22.3 байсныг 2024 онд 45 хувьд хүргэнэ	2021-2024	3.5	Төвөөр үйлчлүүлсэн залуучуудын хувь	2019	22.3	30	Хариуцлагатай - Дундговь аянд Сумын Залуучуудын зөвлөл бага насны хүүхдийг осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 3 таних тэмдэгийг ЕБ-ын 3 сургуулийн орчинд байрлуулан 500000 төгрөг зарцууллаа. "Оролцоод хөгжье" цахим чуулга уулзалтанд сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн, 5 сургуулийн нийгмийн ажилтан, 45 суралцагчид оролцож үзэл бодлоо илэрхийллээ. Аймгийн залуучуудын	100

								<p>хөгжлийн зөвлөлд төрийн байгууллагын 25 албан хаагч томилогдон төлөвлөгөө боловсруулан, цахим чуулга уулзалтанд 1 удаа хамрагдлаа. НҮБ-ын нийгмийн ажлын инновац төслийн хүрээнд Арвижих баг, Нийгмийн ажилтны нэгдсэн төв төслийн багууд хөдөлмөр эрхлэдэггүй, архины хамааралтай 15 иргэнийг санхүүгийн боловсрол олгох, ажлын чиг баримжаа олгох, хувь хүний хөгжил, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх талаар 5 удаагийн сургалтанд хамрууллаа. Үндэсний бичгийн олон талт арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд сумын харъяа төсөвт байгууллагуудын албан хаагчдын дунд анхан, дунд шатны ангилалаар унших, цээжээр бичих төрлөөр уралдаанд 73 албан хаагч оролцлоо.</p> <p>"Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдаараа бахархацгаая" цахим урадаанд 14-35 насны 7 иргэн оролцож 4 иргэн шагналт байранд шалгарлаа.</p>	
2.4.5.1	<p><u>Арга хэмжээ:</u> Залуучуудад чиглэсэн төрийн үйлчилгээг нэмэгдүүлэх</p>	2021-2024	2.0	Сургалтад хамрагдсан залуучуудын тоо	2020	3315	3500	<p>Залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлсэн "Оролцоод хөгжье", "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдаараа бахархацгаая", "Монгол бичгийн уралдаан", 5 удаагийн сургалт, замын постер зэрэг 7 арга хэмжээнд 670 гаруй залуучууд оролцлоо.</p>	100
2.5 Үндэсний бахархал, өв соёл									

2.5.3	<u>Зорилт:</u> Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 1431 байсныг 2024 онд 2587-д хүргэнэ.	2021-2024	171.3	Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо	2019	1431	1720	Сумын “Соёлын сар аян”-ны хүрээнд багийн засаг дарга , нийгмийн ажилтнуудад БСУГ-тай хамтран Соёлын өвийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, ЕБС, цэцэрлэгүүдийн 2800 гаруй хүүхдүүдэд Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулах сургалтын зохион байгууллаа. "СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДААРАА БАХАРХАЦГААЯ" цахим урадаан зохион байгуулж, 18 иргэн оролцож, Арвижих багийн иргэн М.Мөнхнасан “ Уран сийлбэр”, Айраг багийн иргэн Э.Шинэхүү “ 3D эсгий урлал”, Нарлаг багийн иргэн Э.Баттогтох “ Үндэсний бичиг үсэг, Арвижих багийн иргэн Б.Хатанбаатар“ Монгол уран зураг” , Нарлаг багийн иргэн Л.Уранбайгаль “ Уламжлалт гэр ахуй” бүтээлүүд шалгарлаа. Үндэсний бичгээр харъяа төсөвт байгууллагуудын албан хаагчдын дунд анхан, дунд шатны ангилалаар унших, цээжээр бичих төрлөөр уралдааныг 2 шатны ангилалаар зохион байгууллаа 73 албан хаагч оролцож6 албан хаагчийг шагнаж урамшууллаа. Засаг даргын нөөц хөрөнгөөс 420000 төгрөг зарцууллаа.	70
2.5.3.4	<u>Арга хэмжээ:</u> Дуу хуурийн өлгий нутгийн алдартан,	2021-2024	4.0	Алдартан, гавьяатнуудын нэрэмжит болгон зохион	2020	0	2	Суманд АИХ-ын депутат-2, гавъяат цолтой 8 иргэн байна. Сумын цахим хуудсаар алдартан гавъяатуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан,	30

	гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан, алдаршуулах			байгуулсан арга хэмжээний тоо				алдаршууллаа. Цар тахалтай холбогдуулан арга хэмжээ зохион байгуулаагүй.	
2.5.3.6	<u>Арга хэмжээ:</u> Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сумын гэрээт хамгаалагчтай болгох	2021-2024	75.6	Сумдын гэрээт хамгаалагчдын тоо	2020	0	15	Далай багт орших Хаалгын хадны орчмын орон нутгийн тусгай хамгаалалтай газрын 11 иргэнтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хамгаалах талаар мэдээлэл өгч, гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	100
2.5.3.9	<u>Арга хэмжээ:</u> Хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх "Ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч" төслийг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулна.	2021-2024	2.0	Зохион байгуулсан сургалтын тоо	2020	15	16	Сумын "Соёлын сар аян"-ны хүрээнд ЕБСургууль, цэцэрлэгүүд албан хаагч, хүүхдүүдийн дунд Монгол өв соёл, ардын уламжлалт урлагийн талаар нийт 15 сургалт зохион байгууллаа.	100
		2021-2024	3.2	Хамрагдсан хүүхдийн тоо	2020	986	2500	ЕБС, цэцэрлэгүүдийн 2800 гаруй хүүхдүүдэд Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулах сургалтыг зохион байгууллаа. Эх хэлний өдрийг тохиолдуулан үндэсний бичгээ сурталчлах, түүгээр бахархах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ЕБС-ийн 6-12-р ангийн суралцагчдын дунд үндэсний бичгээр хичээнгүй тигээр эх бичих уралдааныг зохион байгуулж, шалгарсан 15 бүтээлийг Хэлний бодлогын салбар зөвлөл шалгаруулан шагнаж урамшууллаа. Уралдаанд засаг даргын нөөц хөрөнгөөс 180000 төгрөг зарцууллаа	100

3. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1 Санхүү, төсвийн зохицуулалт

3.1.2	<u>Зорилт:</u> Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтанд орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2020 онд 30 байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ.	2021-2024	4.8	Орон нутгийн ААН-ийн эзлэх хувь	2020	30	35	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр ШХА-10, НТШ-5 төлөвлөснөөс 2 тендер шалгаруулалтын, худалдан авах ажиллагааг 6 удаа зохион байгууллаа. Үүнд орон нутгийн 6, Улаанбаатар хотын 2 ААНэгж оролцлоо. Мэдээллийг tender.gov.mn-сайт, сумын ЗДТГ-ын пейж хуудсаар иргэд олон нийтэд тогтмол хүргэлээ.	70
3.1.2.1	<u>Арга хэмжээ:</u> Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх	2021-2024	-	Нийт зарлагдсан тендерээс вэбсайт болон пейж хуудсанд урилга, үр дүнг нийтэлсэн тендерийн эзлэх хувь	2020	70	100	Тендер шалгаруулалтын 2 материалын урилга, үр дүнг журмын дагуу нийтэллээ.	100
3.1.2.2	<u>Арга хэмжээ:</u> Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулах	2021-2024	4.8	А3 сертификаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтын тоо	2019	2	2	А3 сертификаттай 71 иргэний судалгааг шинэчилэн гаргалаа. Аймгийн ОНӨГазартай хамтран цахим сургалтыг 2 удаа зохион байгуулж харьяа байгууллагын 19 албан хаагч хамрагдлаа.	100
		2021-2024		А3 сертификат эзэмшигчийн иргэдийн тоо	2020	97	120	2021онд цахим сургалтаар 20 албан хаагч эрхийн үнэмлэх авч, ТА-3 төсөлд ОНӨГазартай хамтран	100

								3 иргэнийг сургахаар шийдвэрлэлээ.	
3.3.2.1	<u>Арга хэмжээ:</u> Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх	2021-2024	4.5	хээлтүүлсэн малын тоо	2020	500	800	Сумын Засаг даргын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Сайнцагаан омгийн хээлтэгчид Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, Монгол үүлдрийн хээлтэгч хонинд "Суффолк" үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч 400 гаруй хонинд зохиомол хээлтүүлгийн ажлыг зохион байгууллаа.	100
4.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО									
4.1 Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ									
4.1.1	<u>Зорилт:</u> Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг 2020 онд 10 хувьтай хэрэгжиж байгааг 2024 онд 80 хувьд хүргэнэ.	2021-2024	60.7	Төрийн цахим үйлчилгээний E-mongolia систем, цахим төслийн хэрэгжилтийн хувь	2020	10	20	Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системээр 10 сарын байдлаар 21 төрлөөр 604 иргэнд лавлагаа, мэдээлэл гарга гаргалаа. Төрлөөр ангилж үзвэл: Вакцины гэрчилгээ 7, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн лавлагаа 1, Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа 3, Гэрлэсний бүртгэлийн лавлагаа 12, Жолоодох эрхийн оноо 1, Жолоочийн лавлагаа, мэдээлэл 115, Иргэнд олгох тодорхойлолт 3, Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа 16, Иргэний үнэмлэхийн лавлагаа 210, Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт 10, Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт 3, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт 70, Регистрийн дугаарын лавлагаа 1,	100

								Төрсний бүртгэлийн лавлагаа 2, Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа 34, Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 22, Үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа, 9 Хуулийн этгээдийн бүртгэлгүй тухай лавлагаа 21, Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа 1, Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (ААНБ) 2, Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (Иргэн) 60	
4.1.1.1	<u>Арга хэмжээ:</u> "Цахим төр-Ухаалаг Дундговь" цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2021-2024	35.0	Хэрэгжилтийн хувь	2020	10	20	10 сарын байдлаар Dundgovi.gov.mn сайтад сумаас зохион байгуулж буй үйл ажиллагааний талаар болон харьяа байгууллагын үйл ажиллагааны 291 мэдээлэл байршууллаа. -“Сайнцагаан сумын засаг даргын тамгын газар” пэйж хуудсанд 506 мэдээлэлийг байршууллаа. 2020 онтой харьцуулахад пэйж хуудсанд байршуулсан мэдээлэл 171 мэдээлэл буюу 13%-иар хисан үзүүлэлттэй байна. Тус пэйж хуудас дагагчийн тоо 5629 хүрлээ. -Байгууллагын удирдлага, албан хаагчид 25 удаагийн цахим хурал, сургалтын үйл ажиллагаанд оролцлоо.	100
4.1.1.3	<u>Арга хэмжээ:</u> Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг сар бүр зохион байгуулах	2021-2024	5.0	Хамрагдсан иргэдийн тоо	2020	0	4000	Аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд долоо хоног бүрийн Бямба гарагт иргэдийн санал хүсэлтийг сонсож байна. Одоогоор 24 иргэнтэй уулзаж 3 өргөдөл хүлээн авч 1 өргөдлийг харъяа	70

								байгууллагад шилжүүлэн 100% шийдвэрлэлээ.	
4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба									
4.2	<u>Зорилго:</u> Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 10 хувьтай байсныг 2024 онд 4 хувиар бууруулна.	2021-2024	83.2	сахилга, ёс зүйн хариуцлага зөрчлийн бууралт хувь	2019	10	9	Сумын “Ёс зүйн зөвлөл” шинэчлэгдэн байгуулагдан 1 удаа хуралдлаа. Одоогоор ёс зүйн зөрчил гараагүй.	30
4.2.1	<u>Зорилт:</u> Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 33.2 хувь байсныг 2024 онд 13.3 хувиар бууруулна.	2021-2024	30.0	томилгооны зөрчлийн бууралт хувь	2020	33.2	23.3	Санхүү албаны дарга жирэмсэн амаржсаны чөлөө авч оронд нь төрийн албаны салбар зөвлөлөөс төрийн албаны нөөцөд байгаа хүн томилох гэсэн боловч нөөцөд хүн байхгүй тул ажлын шаардлагаар төрийн албаны шалгалт өгөөгүй хүн авч ажиллуулж байна. Өөр зөрчилтэй томилгоо хийгдээгүй байна.	30
4.2.1.1	<u>Арга хэмжээ:</u> Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх	2021-2024	5.0	Шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын хувь	2020	10	15	Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим баримтлан мэргэшсэн тогтвортой төрийн албыг бий болгох зарчим баримтлан төрийн албаны тухай болон бусад холбогдох хууль дүрэм журмын дагуу ажиллаж байна.	100

4.2.1.2	<u>Арга хэмжээ:</u> Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах	2021-2024	83.2	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	2020	46	92	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санаачлагаар Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй MERIT төсөлтэй хамтран боловсруулан хүргэж буй “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалт төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний 12 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авлаа. Төсөвт байгууллагуудын бичиг хэргийн ажилтнуудад Монгол бичгийн програмд ажиллах 24 цагийн модуль сургалтанд хамрагдлаа.	70
4.2.2.1	<u>Арга хэмжээ:</u> Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх.	2021-2024	10.0	Авлигаас урьдчилан сэргийлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт хувь	2019	80	85	Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлэх зорилгоор ЗДТГазрын пэйж хуудсаар иргэдэд хүргэлээ. АТГазрын Пэйж болон цахим хуудсанд сумын ЗДТГазар болон харъяа төсөвт байгууллага, 9 багийн пэйж хуудсууд нэгдэж иргэд Авлигийн эсрэг, түүнээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр цаг алдалгүй хангагдахаар боллоо. .	30
4.2.2.2	<u>Арга хэмжээ:</u> Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ) -уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах.	2021-2024	2.5	ЭБАТ-ны сургалт, семинарт хамралтын хувь	2019	80	90	Тамгын газрын дарга аймгийн ХЭЗХэлтэсээс зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-уудын сургалтанд хамрагдан харъяа төсөвт байгууллагын ХАСХОМ гаргадаг 26 албан хаагчдын 90 хувьд нь заавар зөвлөгөө өглөө.	70

4.2.3.1	<p><u>Арга хэмжээ:</u> Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах</p>	2021-2024	3.0	тухайн жилд хууль зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан сумдын тоо	2019	2	3	<p>-Сумын эрх зүйн хөтөч цар тахалтай холбоотойгоор иргэдэд Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөрт зориулан “Бүхий л хайраа гэр бүлдээ”, “Хариуцлагатай эцэг эх байцгаая”, “Хүүхдийг зодож шийтгэх нь хүмүүжлийн арга биш”, “Бяцхан үрсээ айдаст бүү автуулаач” зэрэг уриатай 4 постер, Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Хүүхэд хамгааллын хууль, Малчдын тэтгэврийн хууль, Нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиуд, Төрийн албаны тухай хуулиудыг давхардсан тоогоор 4342 иргэнд хүргэлээ.</p> <p>-Хорио цээрийн дэглэмтэй үед сургуулийн “Gitss erdmiiin urguu” цахим хуудсаар дамжуулан сурагчид болон олон нийтэд аюулгүй амьдрах ухааны сургалт, мэдээлэл агуулсан зурагт хуудсыг доорх 4 чиглэлээр байршууллаа.</p> <ul style="list-style-type: none"> ✓ -Коронавируст халдвараас сэргийлэх ✓ Цахим орчин дахь аюулгүй байдал ✓ Хүүхдийн хүмүүжлийн эерэг арга 	70
---------	---	-----------	-----	---	------	---	---	--	----

								<p>✓ Эцэг эхэд зориулсан сурагчдын зуны амралтын зөвлөмж</p> <p>-Харъяа сургуулийн хамран сургах тойргийн хэмжээнд хөдөлгөөнт эргүүл хийж гэр бүлийн орчинд хүүхдийн дэргэд архидан согтуурах, хүүхдүүд амны хаалтгүй гадуур явах, тоглоомын талбайд бүлэг бөөгнөрөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллаа.</p>	
4.2.3.4	<p><u>Арга хэмжээ:</u> Орон нутгийн ИНБ-уудын оролцоо хамтын ажиллагаанд тулгуурлан жендэрийн боловсрол олгох, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх сургалт, аяныг гэрээлэн гүйцэтгүүлэх</p>	2021-2024	1.5	Жендерийн тэгш бус байдлын индекс	2020	0.825	0.826	<p>“БИ ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫН ЭСРЭГ БАЙНА” аяныг хүрээнд аяны лого, фрем зургаар төрийн байгууллагуудын 300 гаруй албан хаагчид цахимаар давалгаалж, иргэдэд жендэрийн ойлголтыг нэмэгдүүлэх, малчдын дунд “Мотоциклоор биш Мориор малаа хариулъя” уриалга гарган, жолооч нарт авто тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зэрэг контент, зөвлөмжүүдийг боловсруулан цахимаар сурталчиллаа. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах мэргэжилтэн манлайлагчдын гуравдугаар цахим чуулга уулзалт”-д оролцож, төрийн болон төрийн бус байгууллагуудын 2020 онд Жендэрийн талаар хэрэгжүүлсэн ажил болон 2021 онд хэрэгжүүлэх ажлын талаар санал бодлоо солилцож туршлага судаллаа.</p>	100

								Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн ахисан шатны сургалтанд төрийн албан хаагчдыг хамруулж, сумын төрийн байгууллагуудын 120 албан хаагч хамрагдаж сертификат авлаа.	
--	--	--	--	--	--	--	--	--	--

Хэрэгжилт-80%

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

НЭГТГЭСЭН:

ТГ-ЫН ДАРГА

Ц.ЛХАГВАСҮРЭН